



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

Нийслэлийн хүн амд мэс заслын тусламж,
үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын
үйлчлэх хүрээг шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.4, 8.1.12, 8.1.13, Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, Засгийн газрын 172 дугаар тогтоолын 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн хүн амд мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын үйлчлэх хүрээний хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад нэр заасан эрүүл мэндийн байгууллагуудад Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг холбогдох журмын дагуу олгох, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2014 оны 11 дүгээр тушаалын дагуу 2014 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс энэхүү тушаал батлагдсан өдөр хүртэл мэс заслын тусламж, үйлчилгээг үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагуудын эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн асуудлыг нийгмийн даатгалын байгууллагатай хамтран шийдвэрлэхийг Нийслэлийн эрүүл мэндийн газар /Ш.Энхбат /-т үүрэг болгосугай.

3. Нийслэлийн хүн амд мэс засал, гэмтлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эмнэлгүүд нь даатгуулагчдаас тусламж, үйлчилгээний нэмэлт төлбөр авахгүй байхыг эмнэлгийн дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Хавсралтад заасан хуваарийн дагуу нийслэлийн хүн амд мэс заслын лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэхийг Улсын нэгдүгээр төв эмнэлэг /Б.Бямбадорж/, Улсын хоёрдугаар төв эмнэлэг /Г.Баясгалан/, Улсын гуравдугаар төв эмнэлэг /Ц.Төмөр-Очир/ нарт тус тус үүрэг болгосугай.

5. Цаашид дүүргийн хүн амд тусламж, үйлчилгээ үзүүлдэг Нэгдсэн эмнэлгүүдэд Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5095:2013 стандартын дагуу үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг хангаж 2015 оноос үйл ажиллагааг эхлүүлэх, Баянгол дүүргийн иргэдэд гэмтэл согогийн тусламж, үйлчилгээг "Ачтан" эмнэлэгт туршилтын журмаар үзүүлэх ажлыг эхлүүлж тусламж, үйлчилгээг зохицуулж ажиллахыг Нийслэлийн эрүүл мэндийн газар /Ш.Энхбат /-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2009 оны 51 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтын мэс заслын тусламжийг хуваарилсан хуваарь, 2013 оны 151 дүгээр тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа/-д даалгасугай.

САЙД

Н.УДВАЛ

081686

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 06 сарын 19 өдрийн
206 дугаар тушаалын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХҮН АМД МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ
МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭНИЙ ХУВААРЬ

Тусламж, үйлчилгээний төрөл	Дүүргийн нэр									
	Баянтгол дүүрэг	Баянзүрх дүүрэг	Багануур дүүрэг	Батахангай дүүрэг	Налайх дүүрэг	Сонгинохайрхан дүүрэг	Сүхбаатар дүүрэг	Хан-Уул дүүрэг	Чингэлтэй дүүрэг	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
Мэс засал										
	“Номун” эмнэлэг	Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг	Багануур эрүүл мэндийн нэгдэл	Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг	Налайх дүүргийн эрүүл мэндийн нэгдэл	“Мишээл” эмнэлэг	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	“Ачтан” эмнэлэг	“Номун” эмнэлэг /1-9 хороо/, “Ачтан” эмнэлэг /10-19 хороо	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
Лавлагаа тусламж үзүүлэх эрүүл мэндийн байгууллага	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Улсын нэгдсэн эмнэлэг	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	“Ачтан” эмнэлэг	“Номун” эмнэлэг /1-9 хороо/, “Ачтан” эмнэлэг /10-19 хороо	Улсын хоёрдугаар төв эмнэлэг